



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 8 дугаар
сарын 01-ний өдөр

№ 05/09

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга томилох тухай

Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1, 82.2 дахь хэсэг, “Инновэйшн Инвестмент” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 05/03 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Лхагва овогтой Золбаяр-г томилсугай.
2. Л.Золбаярт хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчид мэдээлэл хүргэх, төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулах зэрэг хууль, компанийн дотоод дүрэм, журмаар хүлээсэн үүргээ хариуцлагатай биелүүлэн ажиллахыг үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Л.Золбаяртай байгуулах гэрээ, хэлцэлд Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР